



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасч,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн, 3 нэрийн нийт 48,000,000.00 /дөчин найман сая/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг данснаас хасч хавсралтад заасны дагуу Дорноговь аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга Бригадын генерал Г.Ариунбуян, Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын дарга Г.Бат-Эрдэнэ, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ж.Мөнх-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлтэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Данснаас хассан хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, орон нутгийн өмчит хуулийн этгээд (Дорноговь аймгийн Хөвсгөл, Алтанширээ Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар)-д эзэмшүүлж бүртгэлд тусгах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны 07 дугаар сарын 08 өдрийн
26 дугаар тогтоолын хавсралт

**Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын данснаас хасч Орон нутгийн өмчид бүртгэх
хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хүлээн авах орон нүүтийн өмчит байгууллага
1	Kia forteKU маркийн Галын автомашин, улсын дугаар 34-29 ДГО	1992/2012	Ш	1	11,000,000.00	Дорноговь аймгийн Хөвсгөл сум ЗДТГ
2	ISUZU НЈ 5103 GPSE маркийн Галын автомашин, улсын дугаар 21-64 ДГО	1986/2014	Ш	1	32,000,000.00	Дорноговь аймгийн Алтанширээ сум ЗДТГ
3	Гап унтраах чирдэг төхөөрөмж	7/22/2013	Ш	1	5,000,000.00	Дорноговь аймгийн Хатанбулаг сум ЗДТГ
Нийт дүн					48,000,000.00	